



# ТЭМЭЭ ТӨМОӨ ТИЙМЭЭ





Г.Сэсмээ

# ТЭМЭЭ Том оо Тийм ээ



Улаанбаатар хот  
2007 он

## **Г.Сэсмээ**

### **Тэмээ том со тийм ээ**

Дунд сургуулийн сурагчдад зориулав.

Хянан тохиолдуулсан: О.Монхтуяа


Хянасан: Ж.Гэралмаа

Дизайнер: Н.Хөдөлмөр

Зураач: Х.Болортужа



Хэвлэн нийтлэлийг Интерпрес ХХК  
2007 он



## ТЭМЭЭ ТОМ ОО, ТИЙМ ЭЭ?

### Үнээн хүү минь, тэгдэг юм

- Ээж ээ, ээж ээ!

Торгон шар нэмрэгтэй

Торомгорт хөөрхөн ботго минь

Гангийн наранд цангаж байна уу?

Гадсаа тойроод буйлж явна уу?

Бор ингэ буйлан буйлсаар

Ботгоо санаад ирдэг юм уу?

- Үнээн! Хүү минь, тэгдэг юм

Үрээ амьтан хайрладаг юм.

- Аав аа, аав аа!

Хүй салхи шиг хурдан

Хул зандан унага минь

Хурдааж холдоод төөрчхөв

Хонхорт унтаад хошорчхов гэж

Хулагч гүү яншигээдаг юм уу?

Хурайлж унагаа дууддаг юм уу?

- Үнээн! Хүү минь, тэгдэг юм

Үрээ амьтан хайрладаг юм.

- Эмээ, эмээ!

Сарьдгийн оройд тоших

Сайхан шар болох

Хар нүдэн тугал минь

Халуун сүүгээ ханатал хөхөг дөө гэж

Сүүтэй үнээ сүжирдэг юм уу?

Сүргээсээ түрүүлээд гүйдэг юм уу?


- Үнээн! Хүү минь, тэгдэг юм  
Үрээ амьтан хайрладаг юм.  
- Өвөө, өвөө!  
 Мяндас зөвлөн үстэй  
Магнай халзан хургаа минь гэж  
Хундан цагаан хонь маань  
Хургаа үнэрлэж ээнэгшдэг юм уу?  
- Үнээн! Хүү минь, тэгдэг юм  
Үрээ амьтан хайрладаг юм.  
- Ах аа, ах аа!  
Дэгдэн шовхрох авьяастай  
Дэлдэн цоохор шиг ишиг минь  
Харайж дэгдээд ир дээ, гэж  
Хар ямаа маань майлдаг юм уу?  
- Үнээн! Хүү минь, тэгдэг юм  
Үрээ амьтан хайрладаг юм.



## Тусч хүү

- Хүүе, та минь гарцаарай  
Хүүхэд багачууд хурдаарай  
Үхэр гадаа нийллээ гэж  
Буурал эмээ шухалдав.  
Булт хүн сандрав.  
- Үхэр хэн хариулсан бэ?  
Тугал хэн хариулсан бэ?  
Одоохон тэр нийлэх нь байна.  
Оройн саам алдах нь байна.  
- Морьтой нэг нь мордоорой  
 Морыгүй зарим нь гүйгээрэй гээд л  
Айлын хүүхдүүд цөмөөрөө  
Ам амандаа шуугитал  
Адуучин эрчүүл бүгдээрээ  
Архайж дархайтлаа гартаал,  
Эрээн шамштай хүү





Эрвээлжлээд гарлаа.  
Алаг даахай адил  
Арилаад өглөө.  
Хурдаад гарсан хүү  
Тугалаа эргүүлж амжлаа  
Үглээд байсан хүүхнүүд  
Үнэндээ их баярлалаа.  
Морьтой хүнээс хурдан юм гэж  
Молом эмээ гайхлаа.  
Үнээ тугал нийлүүлээгүй хойно  
Удшийн саам алдуулаагүй хойно  
Хонин тогоо сүү хөөрүүлж  
Хондон шаргал өрөм байлгана.  
Хонгор хүүгээ өглөө босохоор  
Хуруу зузаан өрөм өгнө гэж  
Ээж нь хүүгээ өхөөрдөж байлаа  
Энэ хотныхон магтаж гарлаа.

## Цуваа


Дүүрэн дүүрэн ачаатай  
Дүнхгэр дүнхгэр машинууд  
Үрд хойноо оролцоод  
Үул давааг даваад  
Үудам хөндийг туулаад  
Үс голыг гатлаад  
Хүчээ аваад хүнгэнэнэм  
Хүрэх газраа яарнам

Өчигдөржингөө цувнам  
Өдөржингөө цувнам  
Өдөр бүр цувнам  
Өглөө үдэшгүй цувнам.  
Цувнам, цувнам, цувнам  
Цугаараа ачаатай цувнам  
Хүний хэрэгцээг хангах гэж  
Хүссэн бүхнийг хүргэх гэж  
Хүүхдийн тоглоом өгөх гэж  
Хөгшдийн цайг залгуулах гэж  
Өчигдөржингөө цувнам  
Өдөржингөө цувнам  
Өдөр бүр цувнам  
Өглөө үдэшгүй цувнам.  
Цувнам, цувнам, цувнам  
Цугаараа ачаатай цувнам.  
Ганган дэгжин гоёл ачаад  
Гантиг шилэн эдлэл ачаад  
Бал бурам хүнс ачаад  
Баяр ёслолын идээ ачаад  
Өчигдөржингөө цувнам  
Өдөржингөө цувнам  
Өдөр бүр цувнам  
Өглөө үдэшгүй цувнам  
Цувнам, цувнам, цувнам  
Цугаараа ачаатай цувнам.



## Эмээгийн цай

Манай эмээгийн чанасан цайг  
Маш сайхан болжээ гэж  
Ирсэн гийчин шагшлаг юм  
Энд тэндгүй гайхдаг юм.  
Тогоо дүүрэн ус хийнэ  
Том гараараа идээ үйнэ



Даргитал бушалгаад  
Давс орхино.  
Булаг шиг элбэг сүүнээсээ  
Будаг шиг өтгөн сүүнээсээ  
Будгартал сүлнэ.  
Халгитал самарна.  
Шар тос  
Цөнгийгөөр амтална  
Шар будаа  
Гурилаар хийшэнэ  
Эмээгийн чанасан цай бүхэн  
Ингээд сайхан болдог юм  
Ингээд сайхан болдог нь  
Ирсэн зочдоо дайлах гэсэн  
Элгэн халуун сэтгэлээ  
Идээшсэн цайндаа шингээснийх юм  
Манай эмээгийн чанасан цайг  
Маш сайхан болжээ гэж  
Ирсэн гийчин шагшдаг юм  
Энд тэндгүй гайхдаг юм.

## Үзэг

Хар өнгөтэй сайхан үзэг  
Хайрт найзын дурсгасан үзэг  
Эвтэйхэн гаралттай хөөрхөн үзэг  
Эрдэм сурахыг ерөөсөн үзэг

Бэлгэ дэмбэрлийн гоёхон үзэг  
Бэхээ асгадаггүй цэвэрхэн үзэг  
Бичих, бодох бүрдээ би,  
Бяшхан нөхрөө дурсдаг юм.



## Үудаг цаас

Улаан өнгөтэй уудаг цаас  
Үүл нь бидний найз шүү  
Үрж битгий хаяарай  
Үг ёсоор нь хэрэглээрэй.  
Хөх өнгөтэй уудаг цаас  
Хүүхэд бидний найз шүү  
Хуйлж битгий хаяарай  
Хуудас хэвээр нь хэрэглээрэй.  
Цэнхэр өнгөтэй уудаг цаас  
Цэвэрлэх сайн найз шүү  
Бартаг болсон бэхийн  
Баатар нь ёстай мөн шүү.




## Хув ишигхэн



Барааны дэргэд овоороод л  
Бааганаж ийш тийш давхиад л  
Бавгар хоншиороо долоогоод л  
Байж байгаагий нь, гөлөгний.  
Очиж тэднийг харья  
Овоорч, бахирахы нь сонирхье  
Олгойтой тосноосоо өгье гэж  
Батыг дөхөж очтол  
Цор цор хушаад гөлөгнүүд  
Цувараад урдаас нь давхижээ  
Жов жов гээд хашигсан ч  
Зогсох янзгүй харагджээ.





Банхгар банхгар гөлөгнүүд  
Барид идэх нь ээ  
Байя тэгвэл очихоо гээд  
Бат эргээд зугтжээ.

Хурдааж гүйсээр Бат  
Хурганы пинд оров  
Хув алаг ишиг  
Хажуугаар нь зөрөөд гарав.

Банхгар банхгар гөлөгнүүд  
Бас л ишиг үрүү давхилаа  
Бахимхан эвэртэй ишиг  
Бат шиг айж зугтсангүй ээ.

Үргэж жаахан ухарснаа  
Үсэрч очоод мөргөжээ  
Өнөөхөн банхгар гөлөгнүүд  
Гангинаад цаашаа зугтжээ.

Алаг хув ишиг нь  
“Айлгасан даа би  
Аймхай даа чи” гэх шиг  
Алхсаар пиндээ оржээ.

“Ахиад таануудыг хөөвөл  
Айж би зутгахгүй  
Алаг хув ишиг шиггээ  
Айлган бушааж байя”  
Ингэж Бат бодоод  
Ишиг үрүүгээ харав  
Ишигхэн түүнийг шоолох шиг  
Эврээ сэжлэн зогсов.

## Эрвээхий

Эрвээхий, эрвээхий  
Эргэн эргэн нисээрэй  
Энэ л цэшгэн дээр суугаарай  
Эгиэлж намайг хараарай

Эрээн хувцсы минь хараад чи,  
Эзжийн минь урныг гайхна уу?  
Эгээ л чам шиг би,  
Ижилгүй ганган байна уу?

Эрвээхий, эрвээхий  
Наадан наадан нисээрэй  
Навчин дээрээ буугаарай  
Намайг сайн ажаарай


Эрээн хувцсы минь хараад чи,  
Эзжийн минь урныг гайхна уу?  
Эгээ л чам шиг би,  
Ижилгүй ганган байна уу?



## Тэмээ том oo

Тэмээ том oo  
Тиймээ хө  
Тэгнээ ачаа  
Даана аа хө  
Заан шиг том  
Байтлаа хө  
Зан нь мөн ч  
Сайхан аа хө  
тан тэмээ  
Tom oo хөө  
Ачaa тэгнээ  
Даана аа хө  
Арслан шиг хүчтэй





Байтлаа хө  
Ааш нь мөн сайхан аа хө  
Ингэн тэмээ  
Том oo хө  
Их ээ ачаа  
Даанаа аа хө  
Ийм бяртай  
Байтлаа хө  
Их зангуй нь  
Сайхан аа хө





## Гарчиг

Үнээн хүү минь, тэгдэг юм	3
Тусч хүү	4
Цуваа	5
Эмээгийн цай	6
Үзэг	7
Уудаг шаас	8
Хув ишигхэн	8
Эрвээхий	10
Тэмээ том оо	10







Дэлхийн банктай хамтран хэрэгжүүлж буй  
«Хөдөөгийн боловсролыг дэмжих  
(READ) тесэл»-ийн хурээнд хэвлэв.  
Худалдахыг хориглоно.